


Жанжиажэ - Чангдэ –Фуронг жөн- Жанжиажэ-7 шөнө 8 өдрийн аялал

Өдрийн тоо	Аяллын хөтөлбөр	Хоол	Байрлах газар
Эхний өдөр 7/8	Улаанбаатар→Жанжиажэ Аялагчид оройн 19:00 цагт Жанжиажэ хотод ирээд хил гааль нэвтэрсэний дараа зочид буудалдаа байрлан амарна. Жанжиажэ зочид буудал: Days Inn by Wyndham эсвэл адил зэрэглэлтэй буудал		Жанжиажэ
Хоёр дахь өдөр 7/9	Grand canyon үзэсгэлэнт газар Өглөөний цайны дараа 08:00 цагт [Гранд хавцлын үзэсгэлэнт газар]-ыг үзэхээр хөдөлнө. Шилэн гүүр нь дэлхийн хамгийн өндөр бөгөөд хамгийн урт шилэн гүүр юм. Гүүр нь хавцлын хоёр талын оргил дээр баригдсан бөгөөд гүүрний нум нь газраас 400 метрийн өндөрт байрладаг. Нийт 370 м урттай уг гүүрний голд дэлхийн хамгийн өндөр банжи үсрэлт хийх боломжтой бөгөөд гүүрнээс эгц доошоо 400 метрийн гүнд байрлах хөндийг харах боломжтой. Өдрийн хоол идсний дараа вулин дэлгүүрээр зочилно.   Санал болгох хөтөлбөр: Grand Canyon төсөл (зиплайн + VR + слайд) 240 юань/хүн Санал болгох хөтөлбөр: Шар луугийн агуй 280 юань/хүн Жанжиажэ зочид буудал: Days Inn by Wyndham эсвэл адил зэрэглэлтэй буудал	Өглөө Орой	Жанжиажэ
Гурав дахь өдөр 7/10	Тэнгэрийн хаалга байгалийн үзэсгэлэнт цогцолбор газар Өглөөний цайны дараа 08:00 цагт Туси музей рүү явна. Тужя цэцэрлэгт хүрээлэн нь Жанжиажэгийн байгалийн үзэсгэлэнг хадгалсан гайхамшигт соёлын сувд бөгөөд Тужячуудын тахин шүтэж, мөргөж, залбирч, баяраа тэмдэглэдэг “ариун нутаг” юм. Тэнгэрийн хаалга ууланд байрлах 7455 м урт агаарын дүүжин замаар далайн түвшнөөс 1279 м өндөртэй "Дэлхийн хамгийн урт зорчигч тээврийн зам"-аар дээшилж өгсөхдөө байгалийн гайхамшигтай үзэмжийг сонирхох болно.   Санал болгох хөтөлбөр: Тэнгэрийн хаалганы үнэгэн дагина урлагийн тоглолт 300 юань/хүн Жанжиажэ зочид буудал: Days Inn by Wyndham эсвэл адил зэрэглэлтэй буудал	Өглөө Өдөр Орой	Жанжиажэ

Дөрөв дэхь өдөр 7/11	Үндэсний ойн цэцэрлэгт хүрээлэн-Аватар-Тианзи уул Өглөөний цайны дараа 08:00 цагт Шангпин цайны ордоноор зочилно. Хятадын анхны үндэсний ойн цэцэрлэгт хүрээлэн [Жанжиажэ үндэсний ойн цэцэрлэгт хүрээлэн]-ээр байгальд ээлтэй машинаар очиж, дэлхийн анхны уул өөд гарах Байлун цахилгаан шатаар дээш өгсөж"Аватар" киноны зураг авалтыг хийсэн ууланд очно (ойролцоогоор 1 цаг 30 минут аялана). Энд ирснээр аватар кинонд бүтээсэн Пандора гаригийг нүдээрээ үзэж, биеэрээ мэдрэн байгальд ээлтэй эко машинаар Тианзи цогцолбор газраар зугаална.  Жанжиажэ зочид буудал: Days Inn by Wyndham эсвэл адил зэрэглэлтэй буудал	Өглөө Өдөр Орой	Жанжиа жэ
Тав дахь өдөр 7/12	Happy water world Өглөөний цайгаа уусны дараа 8 цагаас Чангдөд байрлах усан паркийн зүг рүү хөдөлж олон төрлийн гулсуур болон хөгжөөнт тоглоомоор тоглож баяр баясгаланг мэдрэн цагийг зугаатай өнгөрүүлэх болно. Kale planet өндөр технологи бүхий парк нь Kale хот, үлгэрийн хаант улс, нарны овог, аз жаргалын цаг, романтик газар дундын тэнгис гэсэн 5 бүсэд хуваагдана. Парк нь дотроо олон төрлийн тоглоомтойгоос гадна кино, 3D, циркийн үзүүлбэр гэх мэт үзүүлбэрүүд багтсан. Үүний дотор Universal cinema-ийн 30 м-ийн диаметр бүхий дэлхийд 3-т бүсдээ нэг бичигдэх том 360 градусын театрттай. Уг театрт хятадын эртний домогийн үзүүлбэр гардаг бөгөөд үзүүлбэр дунд 180 градус хүртэл эргэх суудал нь үзэгчдэд дэргэд байгаа мэдрэмжийг төрүүлэх болно.  Санал болгох хөтөлбөр: Planet kale парк 200 юань/хүн Чангдө зочид буудал: Чангдө вэй е ян зочид буудал	Өглөө Орой	Чангдө
Зургаа дахь өдөр 7/13	Фуронг жөн Өглөөний цайны дараа 08:00 цагт Моронг Миао тосгон руу хөдөлнө. Үдээс хойш эртний түүх соёлтой байгалийн үзэсгэлэнт газар бүхий эртний гудамж, ардын өвөрмөц зан заншилтай Фуронг сууринд зочилж ардын урлагийн тоглолт үзэж, үдшийн үзэсгэлэнт шөнийн үзэмжийг толидно.	Өглөө Өдөр Орой	Фуронг жөн




Фуронг жөн: Лижинг зочид буудал

Санал болгох хөтөлбөр: Фуронгийн эртний хот дахь шөнийн аялал 200 юань/хүн

Маоян голын үзэсгэлэнт газар:

Өглөөний цайны дараа 08:00 цагаас Маоян голын байгалийн үзэсгэлэнт газар руу хөдөлнө. Аялалын үеэр бид эрэг хавийн хад асга, хүрхрээ, булаг шанднаас гадна байгалийн хачирхалтай бүтэц бүхий уулс, оргилуудыг үзэх боломжтой. Хөлөг онгоцоор аялахад эгц хадан цохио, загас, шувуудын дуулж байгаа нь үнэхээр тааламжтай сайхан.

Завин аялалын зам нь 13 километр, 66 метрийн уналттай, нийт 55 гол нийлэх бөгөөд голын хоёр талын эрэг дагуух хадан хясаа бүхий хүрхрээ, булаг шанд, уулс нь хачирхалтай, аюултай харагдах ба хавцал дундуур усны урсгалд хөвөх нь сэтгэл хөдөлгөх болно.



Санал болгох хөтөлбөр: Шинэ Зеландын тийрэлтэт завь 200 юань/хүн

Жанжиажэ зочид буудал: Days Inn by Wyndham эсвэл адил зэрэглэлтэй буудал

Чөлөөт аялал

12 цагаас зочид буудлаа хүлээлгэн өгч 17:00 цагаас зочид буудлаа цугларч нисэх онгоцны буудлын зүг хөдөлнө. 20:00 цагаас онгоцондоо сууж Улаанбаатарын зүг ниснэ.



Санал болгох: 72 давхар байшин, Жуншан худалдааны төв

Долоо
дахь өдөр
7/14

Найм
дахь өдөр
7/15

Өглөө
Орой

Жанжиа
жэ

Өглөө